



ХӨЛ ХОРИО БА ДОТУУР БАЙРАНД БУЙ ОЮУТНЫ ЗОРЧИХ ЭРХ

НЭГ. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улсад Ковид-19 цар тахлын тохиолдол дотоодод илэрсэнтэй холбоотойгоор 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын 178 дугаар тогтоолоор 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр хүртэл “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” шийдвэр гарсан бөгөөд улмаар нийслэл болон халдвар бүртгэгдсэн орон нутагт энэ хугацааг 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цаг хүртэл сунгаад байна. Тус шийдвэрийг үндэслэн авч буй тодорхой арга хэмжээний хүрээнд дотуур байранд амьдарч буй оюутнуудыг хатуу хөл хорионд оруулсан явдал багтана.

Тодруулбал, 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс Улаанбаатар хотын хэмжээнд оюутнуудыг дотуур байрнаас огт гаргахгүй байгаа болно. Гэвч Засгийн газар, улсын болон нийслэлийн онцгой комиссын шийдвэрт оюутнуудыг дотуур байранд тусгаарлан хатуу хөл хорио тогтоох тухай тусаагүй байна. Харин МУИС-ийн удирдлагын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/322 дугаар тушаалаар “Улсын хэмжээгээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед МУИС-ийн дотооддоо дагаж мөрдөх удирдамж” гаргаж, тус сургуулийн дотуур байранд амьдарч буй оюутнуудыг бүрэн тусгаарлажээ. Ийнхүү “оюутан”-ыг иргэдээс ялган үзэж, ялгамжтай

хязгаарлалт тогтоох эрх зүйн үндэслэл байхгүй тул энэ шийдвэр хүний эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл мөн. Нийслэлийн хэмжээнд хатуу хөл хорионд орсон 11,300 гаруй оюутан¹ байна. Улаанбаатар хотоос орон нутаг руу буцах 86,000 иргэний 30,000 нь оюутан буюу орон нутаг руу буцах иргэдийн 40 хувийг эзэлж байгаа ч орон нутгаас ирсэн иргэдийг бүрэн буцаасны дараа оюутнуудыг буцаахаар Улсын онцгой комисс төлөвлөжээ. Харин орон нутагт гацсан оюутнуудыг тухайн аймгийн онцгой комиссын шийдвэрээр орон нутаг, нийслэл рүү буцаах боломжоор ханган ажиллаж байна. Тухайлбал, Дархан-Уул аймагт дотуур байранд байгаа нийт 751 оюутныг Ковид-19 халдварт цар тахлыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамруулан Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын 51 оюутныг гэрт нь буцаажээ.²

Гэтэл Улаанбаатар хотод дотуур байранд буй оюутнууд хатуу хөл хорионд³ тусгаарлагдаж, орон гэртээ харих, эрүүл хоол, хүнсээр хангагдах эрх нь зөрчигдөж байна. Энэхүү судалгааны хүрээнд дотуур байрны одоогийн нөхцөл байдал, хөл хорионы талаар тодруулах үүднээс тэнд амьдарч буй оюутнуудаас ярилцлагын аргаар судалгаа авсан бөгөөд судалгаагаар дараах нийтлэг зөрчил илэрлээ.

¹ <https://www.montsame.mn/mn/read/245283>

² Дархан-Уул аймгийн Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр өгсөн мэдээлэл.

³ МУИС-ийн дотуур байранд амьдарч буй оюутнуудыг дотуур байрнаас огтоос гаргахгүй байна. Харин зарим хувийн сургуулийн дотуур байрны оюутнуудыг (Эм Ай Юу дээд сургууль) тус байрных нь хашаанаас гарахгүйгээр салхилж болох боломжийг олгосон байна.

Үүнд:

- Оюутнуудыг дотуур байрнаас гаргахгүй байх шийдвэрийг байрны зохион байгуулагч эсхүл жижүүр Засгийн газраас хөл хорио тогтоосон өдөр мэдэгджээ. Ингэхдээ амаар мэдэгдсэн бөгөөд ямар нэг албан ёсны шийдвэр танилцуулаагүй байна. МУИС-ийн зарим оюутанд захирлын тушаал үзүүлсэн⁴ бөгөөд бусад сургуулийн оюутнууд өдийг хүртэл яг ямар шийдвэрийн улмаас байрнаасаа гарч чадахгүй байгаагаа мэдэхгүй байсаар байна. Хүний эрхийг хязгаарлах нь тодорхой шалгуурыг хангасан байх ёстой тул энэ нь ноцтой зөрчил юм.
- Хоол хүнс цуглуулах зорилгоор ч гарч болохгүй байгаа тул оюутнууд хамаатан садан, таньдаг хүмүүсээр зөөлгөх эсхүл ойролцоох дэлгүүрээс хүргэлтээр авч байна. Хүргэлтээр авах тохиолдолд борлуулалтын доод хэмжээ заасан байдгаас (судалгаанд хамрагдсан 2 оюутны хэлснээр 50 мянган төгрөг) тэр хэмжээний мөнгө гаргах боломжгүй оюутны хувьд хүнсээ авахад хүндрэл учирч байна. Түүнчлэн, барааны сонголт муу, хугацаа нь дууссан бүтээгдэхүүн ирүүлдэг, хүргэлт удаан, хүргэлтийн үнэ нэмэгддэг зэрэг хүндрэл тулгарч байгаагаа өгүүлжээ.
- Ихэнх өрөөнд оюутнууд дөрвүүлээ амьдарч байгаа бөгөөд оюутнуудыг сэлгүүцүүлэхгүй байх зорилгоор зарим оюутны байрны бие даах танхимыг хаасан нь үндсэндээ өрөөндөө сууж хичээл хийхээс өөр аргагүй байдалд оруулжээ. Сургалт цахимаар орж буй энэ үед видео хичээлийн чимээ өрөөний бусад оюутанд саад болох зэрэг хүндрэл үүсэж байна. Дийлэнх оюутны байр наслалт өндөртэй, жижиг өрөөнд олуулаа амьдардаг талаар судалгаанд дурджээ.⁵
- МУИС-ийн нэгдүгээр дотуур байрны оюутнуудыг оройн 10 цаг гэхэд өрөөний гэрлээ унтрааж, унтсан байх ёстой гэсэн шаардлага

тавьж байгаа нь оюутнуудад бие даалтаа хийх, шалгалтдаа бэлтгэх боломж өгөхгүй байгааг онцолжээ. Мөн өглөө сэрээрэй гэж хаалга тогшдог зэрэг нь “шорон” шиг сэтгэгдэл төрүүлж байгаа тухай ч мөн хэлж байна. Энэ нь оюутнуудыг сэтгэл зүйн хүнд нөхцөлд оруулах эрсдэлтэй.

- Дотуур байранд амьдарч байгаа оюутны дийлэнх нь орон нутгийн харьяалалтай тул хөл хорио цуцлагдмагц гэр рүүгээ харихаар төлөвлөжээ. Аймаг бүр нийслэлээс ирэх оюутныг хүлээн авахаар төлөвлөсөн ч албан ёсоор оюутнууддаа мэдэгдсэн зүйлгүй байна.
- Оюутнуудыг орон нутаг руу явуулахын өмнө Ковид-19 цар тахлын шинжилгээ авахаар төлөвлөж байгаа хэдий ч 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар ямар нэг мэдээлэл өгөөгүй байсан. Харин Шадар сайдын 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ын 2.6-д “оюутнууд түр журмын 2.2-т заасан www.119.mn хаягаар нэвтэрч бүртгүүлсний дараа Улсын онцгой комиссын шуурхай штабаас гаргасан хуваарийн дагуу шинжилгээний тусгай баг оюутны байр тус бүрт очиж шинжилгээ авна”, 2.7-д “гадуур байрладаг оюутнууд www.119.mn хаягаар орж түр журмын 2.2, 2.3-т заасны дагуу шинжилгээ өгснөөр зорчих эрхтэй болно” гэж зохицуулжээ. Гэвч хэзээ, ямар журмаар оюутнуудыг шинжилгээнд хамруулах нь тодорхойгүй хэвээр байна. Мөн гадуур байрлаж буй оюутнууд өөрсдөө очиж шинжилгээ өгсний дараа зорчих боломжтой ч шинжилгээний хариу 48 цагийн хугацаанд хүчинтэй тул зорчих боломжгүй байдалд хүрчээ. Учир нь оюутнуудын нийслэлээс гарах хугацааг бусад иргэдтэй харьцуулахад ялгамжтай тодорхойлсон.

Дээрх нөхцөл байдлыг дүгнэвэл, дотуур байранд үйлчилж буй хөл хорионы дэглэмийг “шорон”-той зүйрлэж буй оюутнуудын сэтгэгдлийг бүрэн үгүйсгэх

⁴ Судалгааны баг МУИС-ийн оюутны байранд амьдарч буй оюутнуудын дунд цахимаар судалгаа хийсэн бөгөөд ингэхдээ ярилцлагын аргыг ашигласан болно.

⁵ БСШУСЯ “Тайлан: дээд боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хүрэлцээ, хангамж, орчин нөхцөлийн судалгаа” 2019 он.

<https://www.herp.mn/uploads/Dotuur%20bairnu%20ajlun%20hesgiin%20tailan%2020190117.pdf>

аргагүй байна. Нөгөөтэйгүүр, Засгийн газар, УОК-оос гарсан шийдвэрт оюутнуудыг тусгайлан хатуу хөл хорионд байлгах асуудал тусгагдаагүй байтал

юуны учир ийм үр дүнд хүрсэн болохыг тодруулах шаардлагатай.

ХОЁР. АСУУДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Их, дээд сургуульд сурч байгаа иргэдийг “оюутан” гэх ангилалд оруулснаар ялгавартай хандахад хүргэх ёсгүй. Үүнийг Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” хэмээн баталгаажуулсан. Тиймээс оюутнууд бусад иргэдийн адил тэгш боломжоор⁶ хангагдах ёстой. Хэдийгээр эрх нь хязгааргүй боломж биш ч хязгаарлалт нь зөвхөн хуульд заасан үндэслэл, журмаар явагдах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэнд, бусад хүний эрх чөлөөг хамгаалах зэрэг зүй ёсны зорилгод нийцэх, энэ зорилгод хүрэхэд зайлшгүй тохирсон байх⁷, эрүү шүүлтээс ангид байх⁸ зэрэг туйлын эрхүүдийг хөндөөгүй байх, хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхаагүй, нэр төрийг нь доромжлоогүй байх гэсэн 5 шалгуурт нийцэх учиртай.⁹

Оюутнуудад чиглэсэн дээрх арга хэмжээ нь дээрх 5 шалгуурын хэд хэдэн шаардлагыг зөрчсөн байна. Үүнд:

1. Хууль, бусад шийдвэрээр тогтоогоогүй байхад оюутнуудыг хатуу хөл хорионд оруулсан нь хуульд заасан үндэслэл журмаар явагдаагүй болохыг илтгэж байна.

2. Хязгаарлалт нь ялгаварлан гадуурхаагүй байх ёстой.¹⁰ Гэтэл зөвхөн оюутан гэх шалтгаанаар бусад иргэдээс ялгамжтай хандсан нь энэ шалгуурыг зөрчихөд хүргэжээ.
3. Хязгаарлалт нь тохирсон буюу зайлшгүй байх ёстой.¹¹ Тохирсон байх гэдэг нь аливаа арга хэмжээ, ял шийтгэл зайлшгүй шаардлагатайгаас илүү хүнд, хатуу байж болохгүй гэсэн үг юм.¹² Гэтэл оюутнуудыг цар тахал авсан иргэдтэй адил дэглэмээр, гэхдээ илүү урт хугацаагаар тусгаарласан. Мөн орон нутаг буюу гэр рүүгээ явах боломжийг бүрдүүлээгүй. Тиймээс тохирсон буюу зайлшгүй байх шаардлагыг зөрчсөн гэж үзэж байна.
4. Үндсэн эрхийг аль болох эдлүүлэх ёстой. Тухайлбал, эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангагдах, сурч боловсрох, эм, эмнэлгийн тусламж авах эрхийг аль болох эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Гэтэл оюутнууд хүргэлтээр чанаргүй хүнс авах, шөнийн 10 цагаас хойш гэрлээ унтраахад хүрч байгаа нь дээрх шаардлагыг зөрчжээ.

Түүнчлэн Коронавирусын цар тахалтай холбоотойгоор НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг дэд хорооноос оролцогч улс орнуудад энэ оны 3

⁶ Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт

⁷ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.3 дахь заалт, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 11.2 дахь заалт

⁸ Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт

⁹ О.Мөнхсайхан “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт”, Ардчиллын хөгжил—Иргэдийн оролцоо ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2017, 91-108 дахь тал.

¹⁰ Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт

¹¹ Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт

¹² О.Мөнхсайхан “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт”, Ардчиллын хөгжил—Иргэдийн оролцоо ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2017, 91-108 дахь тал.

дугаар сарын 25-ны өдөр зөвлөмж өгсөн.¹³ Тус зөвлөмжид “Ямар нэг байдлаар хөл хорионд орсон хүнийг хоригдол мэт харж, харьцаж үл болно”, “хөл хорионд орсон хүмүүсийг байршуулсан газар нь хэмжээ, зайны хувьд хангалттай байх шаардлагатай ба тухайн байгууламж дотроо өөрийн хэрэгцээ шаардлага хангахад нийцэхүйц хэмжээний

хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх”, “бодит байдал дээр хөл хорио тогтоох нь тодорхой хэмжээнд хорьж байгаагийн хэлбэр бөгөөд хөл хорионд орсон хэн бүхэн хөл хорионд орсон шалтгааны талаар мэдээлэл авах, хараат бус эмнэлгийн зөвлөмж авах, хууль зүйн туслалцаа авах эрхүүдийг хязгаарлаж болохгүй¹⁴” гэж дурджээ.

ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ



1. Орон нутгийн иргэдийг буцаасны дараа оюутнуудыг буцаах тухай шийдвэрээ цуцалж, бусад иргэдийн адил 2020 оны 12 дугаар сарын 1-10-ны хооронд гэр рүү нь буцаах арга хэмжээ авах;
2. Оюутны дотуур байранд үлдэх хүсэлт гаргасан оюутнуудыг хатуу хөл хорионы нөхцөлд тусгаарлахгүй байх;
3. Оюутны дотуур байрны нэг хүнд ногдох агааржуулалтын нөхцөлийг сайжруулах, энэ үндсэн дээр нийтийн танхимыг ашиглах боломж бүрдүүлэх;
4. Оюутнуудад шаардлагатай хүнсээ цуглуулах, эм, эмнэлгийн тусламж авах нөхцөлийг бүрдүүлэх, гадаа агаарт гарах боломжоор хангах;
5. Дээрх шалтгаанаар гадуур гарах тохиолдолд технологи ашиглан явсан маршрутыг тогтоох, урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлэх;
6. Хичээл цахимаар орж буй тул сурч боловсрох эрхийг хангах үүднээс интернэт, суурин компьютер ашиглах нөхцөлөөр хангах;
7. Дотуур байранд амьдарч буй оюутнуудад хэрхэн, яаж шинжилгээнд хамруулах тухай нээлттэй, хүртээмжтэй мэдээлэл хүргэх;
8. Тусгаарлалын үед хэрэгжүүлж буй арга хэмжээний үргэлжлэх хугацаа болон шаардлагатай бусад мэдээллийг оюутнуудад нээлттэй, шуурхай, хүртээмжтэй өгөх;
9. Оюутнууд хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх бололцоогоор хангах.

¹³ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос урьдчилан сэргийлэх үндэсний механизм болон оролцогч улс орнуудад 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өгсөн зөвлөмж. Хүний эрх сэтгүүл: Онол, арга зүйн сэтгүүл. Улаанбаатар хот., 2020/№1, 95-96 дахь тал

¹⁴ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос урьдчилан сэргийлэх үндэсний механизм болон оролцогч улс орнуудад 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өгсөн зөвлөмж. Хүний эрх сэтгүүл: Онол, арга зүйн сэтгүүл. Улаанбаатар хот., 2020/№1, 95-96 дахь тал

